



1. Уул уурхайгаас хөгжилд оруулах хувь нэмэрийг өгөөжтэй болгох

Олон улсын хөрөнгө оруулалтыг дэмжсэн, уул уурхайн салбарт эзэмшлийн асуудлыг тодорхой тусгасан, хууль эрх зүйн зохицуулалт нь ил тод байх бодлогыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Засаглалын нээлттэй зарчмыг баримталснаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж улмаар Монгол Улсын эдийн засгийн хөгжил дэвшил урагшилна.

2. Ашгийн буюу орлогын 51%-ийг төрийн эзэмшилтэй харьцуулах нь

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын 51%-ийг эзэмшихтэй холбогдсон зардал чирэгдэл, давуу талыг цэгнэж үзэх ёстой. Улмаар уул уурхайн салбарт зохицуулалт хийхдээ эдийн засгийн өсөлт, хөгжлийн асуудлыг тэргүүн зэргийн зорилт болгон тавих хэрэгтэй. Гадаадын компанитай ашиг хуваахад улс 51%-ийг авах нь Монголын ард иргэдэд өгөөжтэй байхаас гадна гадаадын хөрөнгө оруулагчдад цаашид хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх болно. Харин төрийн эзэмшил давуу байх тохиолдолд засгийн газраас улс орны хөгжилд шаардлагатай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө багасч, эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах ажлын эрч саарах болно.

3. Татвар, ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөрийн зөв, шударга тогтолцоог бий болгох

Уул уурхайн салбарын өвөрмөц онцлогийг тусгасан, татвар, ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөрийн тогтолцоог адил тэгш байх зарчмын үндсэн дээр бүрдүүлэх уул уурхайн бодлого баримтлах. Уул уурхайн ажил бол өндөр эрсдэлтэй, ихээхэн хөрөнгө шаарддаг бөгөөд алслагдсан, амьдрах нөхцөл хүнд нутаг дэвсгэрт явагддаг. Татварын оновчтой бодлого нь хөрөнгө оруулалтыг дэмжих явдлыг татвар үр ашигтай байх нөхцөлтэй тэнцвэржүүлсэн байдлаар хийгдэх ёстой. Гэнэтийн ашгийн татвар зэрэг хувилбар нь уул уурхайн салбарын цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлж хөрөнгө оруулагчдыг мөнгөө татахад хүргэдэг. Ингэснээр Засгийн газар нь уул уурхайгаас олох татварын эх үүсвэрээ алдаж эрдсийн баялагаа ашиглан эдийн засгийн өсөлтийг бий болгох боломжоо алдахад хүрнэ.



4. Зохицуулалтын зөв, шударга тогтолцоог бий болгох

Уул уурхайн төслүүдийн арилжааны үр ашиг нь тухайн төсөлд засгийн газраас үзүүлж буй ачааллаас хамаардаг учраас уул уурхайн бодлогод зохицуулалтын хүрээг шударгаар тогтоосон байх ёстой.

5. Дэд бүтцийг хөгжүүлэх нь

Монголын засгийн газар дэд бүтцийг бий болгохдоо Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулагчийг татан оролцуулж зардлаа хуваах нь зүйтэй. Уул уурхайн томоохон төслүүд нь олон жилийн туршид олон тэрбум доллараар хэмжигдэх хөрөнгө оруулалтыг шаарддаг. Тиймээс засмал болон төмөр зам, эрчим хүчний эх үүсвэрт ойр байхаас уул уурхайн төслийн үндсэн өртөг зардал голчлон хамаардаг. Засгийн газраас холбогдох уул уурхайн компаниудын оролцоотойгоор дэд бүтцийг хөгжүүлэх нь уул уурхайн төслүүдийн арилжааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тухайн улс орны хөгжил дэвшилд гол хувь нэмэр оруулах болно.

6. Үр ашгаа ил тод хуваарилах

Иргэний нийгэм, хувийн хэвшил зэрэг нийгмийн төрөл бүрийн хэсэгт ил тод, тунгалаг байх зарчмыг баримтлан уул уурхайн салбараас олох орлого, төлбөрийг нээлттэй, тайлагнасан байдлаар хуваарилах ёстой. Уул уурхайн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн ард иргэдэд шууд ашиг тусаа өгч байгааг тэд үзэж, мэдэрч байх явдал чухал. Ингэж чадаагүйгээс орон нутагтай зөрчилдөж улмаар уурхайн төслийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байдал бий болно. Ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөрийн дор хаяж зохих хэсгийг орон нутгийн засаг захиргаанд шууд өгөх нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой юм.

7. Байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тэргүүн туршлага нэвтрүүлэх

Монгол Улсын засгийн газраас болон уул уурхайн компаниудын зүгээс хөдөлмөр, байгаль хамгааллын стандартыг тогтоохдоо дэлхийн улс орнуудын тэргүүн туршлагаас нэвтрүүлэх. Байгаль орчныг хамгаалах асуудлыг баталгаажуулсан, үндэсний хөдөлмөрийн хууль тогтоомжтой бүрэн нийцсэн, орон нутгийн иргэд, засаг захиргаатай үр нөлөөтэй зөвлөлдөж, хамтран ажиллах үндсэн дээр гаргасан бодлого нь уул уурхайн салбар, Засгийн газар, орон нутгийн хүй хамтлаг гар нийлүүлэн хамтарч



эдийн засгийн өсөлтийг хангах, өв уламжлалыг хадгалан үлдээх боломжийг бүрдүүлж чадна.

8. Дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар

Уул уурхайн салбарт дэлхийн хэмжээнд өрсөлдөж чадах бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Бусад салбарын нэгэн адил уул уурхайн компаниуд нь дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай байхын зэрэгцээ үндэсний эдийн засагт болон хувцаа эзэмшигчдээ бүрэн хэмжээгээр үр ашигаа хүртээх учиртай. Эрдсийн баялагтай улс орон олон байгаа ч тэр болгон өгөөжийг нь бүрэн хүртэж чаддаггүй байна. Тиймээс Монголын засгийн газрыг ашигт малтмалын хайгуул, олборлолтоор дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай байхаар Ашигт малтмалын хууль гаргаасай гэж бид хүсэж байна. Ингэж эс чадваас Монгол улс эрдсээр баялаг ч шилжилтийн эдийн засагтай, ядуу бусад улсын нэгэн адил сүүл мушгисаар байх болно.

9. Төр, засгийн үйл ажиллагаа ил тод, хариуцлагатай байх

Бүх түвшинд төр, засгийн байгууллагууд болон бодлогыг ил тод, хариуцлагатай болгохуйц сайн засаглалыг хэрэгжүүлэх нь Монгол улсыг эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшлийн замаар хөглөнө.